



ДУНДГОВЬ АЙМАГ
ЛУУС СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А/17

Цагаан-Овоо

Зохион байгуулалтын
арга хэмжээ авах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а" Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2021 оны 02 дугаар хурлын шийдвэр, Аймгийн Засаг даргын 2021 оны А/53 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг.Коронавирус (КОВИД-19) халдвараас урьдчилан сэргийлж, эрсдэлийг бууруулах зорилгоор аймаг сум хооронд зорчих иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2021 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 20:00 цагаас 02 дугаар сарын 15-ны өдрийн 06:00 цаг хүртэл түр хязгаарласугай.

Хоёр.XVII дугаар жарны Цагаагчин үхэр жилийн хаврын тэргүүн сарын шинийн нэгэн, Монголын цагаан сарын баярын үеэр иргэдийг гэртээ зочин урих, айлд зочлохыг, албан байгууллага, аж ахуй нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудын албан хаагчид болон иргэд олон нийтийг хамруулсан золголтын арга хэмжээ зохион байгуулахыг тус тус хориглосугай.

Гурав.Монголын цагаан сарын баярыг сумын нутаг дэвсгэрт баг байгууллагын хэмжээнд иргэд олон нийтээр өргөн тэмдэглэхгүй байж Коронавируст (КОВИД-19) цар тахлаас урьдчилан сэргийлэх эрсдэлийг бууруулах ажлыг сумын төрийн байгууллага албан тушаалтнуудыг оролцуулан зохион байгуулахыг сумын Онцгой комисс, Шуурхай штабын дарга, Төрийн байгууллагын дарга удирдлагуудад үүрэг болгосугай.

Дөрөв.Голомтот бүс нутгаас ирсэн иргэд гэрийн ажиглалтад байх хугацаанд гэрээс гарахгүй, хорио цээрийн дэглэмийг баримталж мэргэжлийн байгууллагаас өгч

Боловсруулсан
Хансан
Хүрэг
Огноо

байгаа заавар зөвлөмжийг дагах, халдвар хамгааллын дэглэмийг мөрдөхийг тус иргэдэд уриалсугай.

Тав.Сумын Онцгой комиссын үйл ажиллагааг эрчимжүүлэх, баяр амралтын өдрүүдэд ажиллах эргүүлийг томилон үүрэг гүйцэтгүүлэх, иргэд тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавих, голомтот бүс нутгаас ирсэн иргэдийг гэрийн ажиглалтын хяналтыг сайжруулах арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг сумын Шуурхай штабын дарга /Б.Энхжаргал/-д үүрэг болгосугай.

Зургаа.Захирамжийн хэрэгжилтийг хангуулж хяналт тавьж ажиллахыг Сумын Засаг даргын орлогч /Т.Алтангадас/, Хэсгийн төлөөлөгч /С.Батбаяр/, Эрүүл мэндийн төвийн дарга /Г.Наранжаргал/, Багийн Засаг дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ӨЛЗИЙХИШИГ